



**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

2016 ТАЙЛАН



**Улаанбаатар хот
2017он**

**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

2016 ТАЙЛАН

-
1. Алтны зах зээлийн судалгаа
 2. Зэсийн зах зээлийн судалгаа
 3. Нүүрсний зах зээлийн судалгаа
 4. Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа
 5. “Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт: Ерөнхий тэнцвэрийн загварчлал” судалгаа
 6. Жижиг, дунд үйлдвэрийн хэлцлийн зардлын судалгаа
 7. Монголын өрхийн секторын стресс тестийн загвар
 8. Дундаж давхаргын судалгаа
 9. Богино болон дунд хугацааны эдийн засгийн төсөөлөл
 10. Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Товч танилцуулга

МУИС-ийн дэргэдэх эдийн засгийн бодлого судлалын төв болох Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн 2010 онд байгуулагдсан. Чанарын өндөр түвшний, мэргэжлийн хөндлөнгийн хяналтаар шүүгдсэн, хараат бус, оновчтой асуудал дэвшүүлсэн эдийн засгийн бодлогын шинжилгээ, судалгааны ажлыг хийх, санхүүжүүлэх, эдгээр судалгааны гол үр дүнг нийтэд хүргэх, бодлогын судалгаа хийх хэрэгцээг тодорхойлж төрийн болоод бусад байгууллагад танилцуулах гол зорилготой.

Тус хүрээлэн МУИС-ийн эрдэмтэн, багш нарын судалгаа хийх чадавхад голлон суурилагаас гадна бусад судлаач, шинжээчдийг үйл ажиллагаандаа идэвхтэй оролцуулдаг.

Гол харилцагчид:

- ◀ Монголбанк, Сангийн яам, Хөдөлмөрийн яам зэрэг төрийн байгууллага
- ◀ Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ, Жайка зэрэг олон улсын байгууллага


2016 онд хэрэгжүүлсэн судалгааны төслүүд

Алтны зах зээлийн судалгаа

Алт нь Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүнүүдийн нэг бөгөөд төв банкны гадаад нөөцийн сан, төсвийн орлогын чухал үүсвэр болдог. Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA)-тай хамтарсан энэхүү судалгаагаар дэлхийн алтны эрэлт, нийлүүлэлт, үнийн өөрчлөлтөд нөлөөлж буй өнгөрсөн болон өнөөгийн хүчин зүйлсийг судлахыг зорьсон.

Уг судалгаагаар 2010 оноос хойших хугацааг хамруулан үндсэн гурван хүрээг авч үзсэн. Юуны өмнө, дэлхийн алтны эрэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ. Судалгаанаас харахад, гоёл чимэглэлийн эрэлт нь нийт эрэлтийн гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2017 он хүртэл сүүлийн гурван жилийн хугацаанд буурсаар байна. Ялангуяа, Хятадад алтны таашаалын шилжилт, Энэтхэгийн гол бүсүүд дэх эдийн засгийн хүндрэлүүд алтны эрэлтийг сулруулжээ. Түүнчлэн, төв банкны худалдан авалт, алтыг хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгон авч буй нь эрэлтийн таамаглал хийхэд улам түвэгтэй болгож байна. Мөн технологийн зорилгоор ашиглаж буй алтны хэрэглээ харьцангуй буурсан бөгөөд тус зах зээлд алтыг өөр бүтээгдэхүүнээр орлуулах нь ихэссээр байна.

Зураг 1. Нийт эрэлт улсаар, 2010-2016 он, тонн




Эх сурвалж: Дэлхийн алтны холбоо

Хоёрдугаарт, дэлхийн алтны нийлүүлэлтийн хүрээнд хийсэн шинжилгээний хэсэгт алтны үйлдвэрлэлийн гол төлөвийг тайлбарласан. Тухайлбал, зарим хэлбэлзлийг үл тооцвол алтны үйлдвэрлэл ихсэх хандлагатай байгаа боловч компаниуд үйлдвэрлэлийн зардлаа ихээр танаж байна. Түүнчлэн алтны компаниуд хайгуулын зардалд харьцангуй багыг зарцуулж байна. Жишээлбэл, сүүлийн хоёр жилд 6 сая унцаас дээш нөөцтэй хоёрхон орд л илрүүлжээ. Үүнээс үзэхэд, хэдийгээр нийт үйлдвэрлэл өсөх хандлагатай байгаа боловч зарим эх сурвалжийн таамаглалаас харахад урт хугацааны нийлүүлэлтийг таамаглахад хэцүү болж байна.

Гуравдугаарт, алтны үнийг авч үзвэл, 2012 оноос хойш алтны үнэ 30 орчим хувиар унаад байна. Сонирхолтой нь энэхүү бууралттай харьцуулахад 2016 онд алтны үнэ дахин сэргэсэн. Эдийн засгийн тогтворгүй байдал, алтны гол үйлдвэрлэгч, хэрэглэгч улсуудын улс төрийн орчноос болж алт нь санхүүжилтийн таатай хэрэгсэл болоод байна. Хэдийгээр алт өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 1200 ам.доллар орчимд хэлбэлзэж байсан боловч 2017 онд болон ирээдүйд ямар байх нь таамаглахад түвэгтэй хэвээр байна. Дэлхийн томоохон банкнууд болон зөвлөх байгууллагууд алтны үнийг 2017 онд дунджаар 1244 ам.доллар байна гэж таамаглаад байна.

Зураг 2. 2017 алтны үнийн таамаглал, топ 10 байгууллагуудаар



Эх сурвалж: Лондонгийн Алтны Зах зээлийн Холбоо

Бид судалгааныхаа хэсэг бүрд Монголын алтны үйлдвэрлэл болон экспортын шинжилгээг оруулсан. Монгол Улс алтны зах зээлд үнэ хүлээн авагч бөгөөд олборлосон алтны цорын ганц худалдан авагч нь Монголбанк юм. Өнгөрсөн хугацаанд ашгийн татвар болон бодлого, дүрэм журмын өөрчлөлт нь алтны үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байсан. Эдүгээ алтны зах зээл алтны шороон ордоос илүүтэйгээр үндсэн ордуудыг илрүүлэх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, алтны компаниуд ирээдүйд үйлдвэрлэлээ эрхлэх их хэмжээний капиталтай болоод байгаа юм. Оюу толгой манай улсын хувьд алтны гол үйлдвэрлэгч боловч дэлхийн хэмжээний нөөцтэй харьцуулахад хараахан гол тоглогч болж чадахааргүй байна.


Зэсийн зах зээлийн судалгаа

Энэхүү судалгаа нь дэлхийн болон Монголын зэсийн зах зээлийн төлөв байдал, цаашдын хандлагыг судлах зорилготой.

Зэс нь цахилгаан, дулааныг маш сайн дамжуулдаг, уян хатан, бат бөх, хүрэл гууль зэрэг бусад металлтай нэгдэх чадвартай үндсэн металлуудын нэг. Иймд дэлхийн нийт зэсийн хэрэглээний 50 гаруй хувийг тоног төхөөрөмжийн салбарт, дараагаар нь барилга, дэд бүтцийн салбаруудад бүрдүүлж байна. Хятадын аж үйлдвэржилт, эдийн засгийн өсөлтөөс шалтгаалан сүүлийн 50 жилд зэсийн хэрэглээ 3 дахин өссөн. Дэлхийн металлын статистикийн газрын мэдээлснээр, 2015 онд зэсийн хэрэглээ 23 сая тоннд хүрсэн бөгөөд Хятад улс дангаараа тал хувийг нь, АНУ, Герман, Япон, Өмнөд Солонгос, Итали, Энэтхэг, Турк, Тайван зэрэг улсууд 30 орчим хувийг нь хэрэглэжээ.

Чили, Перу, Индонез, Хятад зэрэг улсууд зэсийн гол үйлдвэрлэгчид бөгөөд манай улс 2015 оноос эхний 20-д багтах болжээ. Монгол орон зэсийн арвин их нөөцтэй, 2015 оны байдлаар 80 гаруй сая тоннын таамаг нөөц илрээд байгаа ба 1980-аад оноос хойш зэсийн баяжмалыг үйлдвэрлэн, экспортолж байна. Зэс боловсруулах үйлдвэр сүүлийн арваад жилд хөгжиж эхлэн, 2014 оноос жилд 13000 тонн цэвэр

Зураг 3. Монголын нийт уул уурхайн болон зэсийн баяжмалын экспорт (1995-2016)




Эх сурвалж: Дэлхийн алтны холбоо

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс улбаалан Монголын нийт экспорт 2011 онд 4.8 сая тэрбум ам.долларт хүрч байсан. Үүний 47 хувийг нүүрс, 20 хувийг зэсийн баяжмалын экспорт эзэлж байсан бол 2014 оноос эхлэн Оюу Толгойн нөлөөгөөр зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ хоёр дахин өсөн нийт экспортын 40 орчим хувийг эзэлж байв. Хэдий тийм ч дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн бууралтаас үүдэн баяжмалын экспортын дүн 2016 онд 1.6 сая ам.доллар болон буурлаа.

Судалгааны гол үр дүн:

- Судлаачдын үзэж байгаагаар, дэлхийн зэсийн эрэлт цаашид тогтвортой байх ба үүнд Хятадын эрэлт, АНУ, Европ зэрэг хөгжингүй орнуудын тогтвортой эрэлт болон Энэтхэг, Зүүн өмнөд Ази зэрэг хөгжиж буй орнуудын хэрэглээний өсөлт нөлөөлнө. Тухайлбал, 2030 он хүртэлх жилийн дундаж зэсийн эрэлтийн өсөлт хөгжингүй орнуудынх -0.6% байх бол хөгжиж буй орнуудын 3.6% байна гэж таамагласан. 2017-2018 онд зэсийн нийт эрэлт 24 сая тонн буюу өнгөрсөн жилтэй ойролцоо түвшинд байх ба цаашид харьцангуй тогтвортой, жилд 1-3 хувь өсөх хандлагатай байна.
- Хятад дэлхийн зэсийн эрэлтийн 50 орчим хувийг бүрдүүлж буй гол тоглогч бөгөөд цаашид энэ хандлага үргэлжилсэн хэвээр байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд Хятадын эдийн засгийн өсөлт удааширч, 13 дахь таван жилийн төлөвлөгөөгөөр аж үйлдвэржилтээс үйлчилгээ, хэрэглээ рүү чиглэсэн эдийн засгийг дэмжиж байгаа ч зэсийн эрэлтийг үүсгэж буй суурь хүчин зүйлс хэвээр байна. Тухайлбал, Хятадын хотжилтын бодлого, хүн амын өсөлт болон өсөн нэмэгдэж буй тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийн хэрэглээ, одоогийн дэд бүтцийн сайжруулалт, засвар үйлчилгээ зэрэгтэй холбоотойгоор Хятадын цахилгаан шугам сүлжээ, барилгын салбар, тоног төхөөрөмж, автомашины салбарт үүсэх зэсийн эрэлт цаашид өндөр хэвээр байх болно.
- Дэлхийд зэс үйлдвэрлэлээр тэргүүлэгч гурван улс нь Чили, Перу, Хятад бөгөөд нийт нийлүүлэлтийн 30 орчим хувийг Чили улс дангаараа бүрдүүлдэг. Монгол 2015 онд эхний 20 зэс үйлдвэрлэгчийн тоонд орсон ба Хятадтай зэсийн баяжмалын худалдаа хийсэн Чили, Перугий дараа гуравдагч нийлүүлэгч улс болоод байна. Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл төлөвлөсний дагуу 2022 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлбэл манай улс дунджаар 600-800 мянган тонн зэсийн агуулгатай 2.4-2.6 сая тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болно. Мөн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор ойрын жилүүдэд Монгол Улсад 4.6 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх төлөвтэй байна.
- 2012 оноос хойш дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ тасралтгүй буурч, 2016 онд тонн зэсийн жилийн дундаж үнэ 4879 ам.долларт хүрлээ. Үнийн бууралтаас үүдэн зэсийн зарим уурхай үйлдвэрлэлээ багасгах, түр зогсох, үйлдвэрлэлийн өргөжилтөө хойшлуулах зэрэг арга хэмжээ авч ирсэн нь нийт зэсийн нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж байгаа юм. Мөн дэлхий даяар хүдэр дэх зэсийн агууламж буурч байгаа, улс орнуудын төрийн бодлого, шинэчлэлтэй холбоотойгоор 2019 оноос эхлэн зэсийн нийлүүлэлтийн хомсдол үүснэ гэж судлаачид таамаглаж байна. Ойрын хугацаанд буюу 2017, 2018 онд үйлдвэрлэж нөөцлөгдсөн зэс дуусаж, эхлэн дэлхийн зах зээл дээрх зэсийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл хангагдахаар байна.
- Дэлхийн зэсийн эрэлт, нийлүүлэлтийн хандлага болон бусад хүчин зүйлээс шалтгаалан Дэлхийн банк, ОУВС, Оюу Толгой ХХК зэрэг нь зэсийн үнийг хэрхэн таамагласныг доорх зурагт харууллаа. Ойрын 2-3 жилд зэсийн зах зээлд тэнцэл хангагдах боловч урт хугацаанд нийлүүлэлтийн хомсдолоос үүдэн зэсийн үнэ өсөх ажээ.

Зураг 4. Зэсийн үнийн таамаг (2015-2019)




Эх сурвалж: ОУВС (2016.12), ДБ (2017.01), ОТ (2016.10)

Нүүрсний зах зээлийн судалгаа

Монгол Улсын эдийн засгийн бүтэц уул уурхайн салбараас хэт хамааралтай болж байгаа өнөө үед уул уурхайн салбарыг илүү гүнзгийрүүлэн судалж, улмаар салбарын боломж болон эрсдэлийг үнэлэх нь урт хугацааны бодлого боловсруулахад чухал юм. Хэдийгээр, энэ судалгаанд уул уурхайн салбарыг бүхлээр нь авч үзээгүй боловч салбарын гол бүтээгдэхүүнүүдийн нэг болох нүүрс¹-ийг онцгойлон авч, түүний эрэлт, нийлүүлэлт болон үнэ тогтолт гэсэн үндсэн 3 бүлгийн хүрээнд судаллаа. Мөн судалгаанд нүүрс гэж ерөнхий байдлаар авч үзэхээс зайлсхийж, коксжсон болон эрчим хүчний нүүрс гэж ангиллаа. Учир нь, энэ хоёр төрлийн нүүрсний эрэлт, нийлүүлэлт, үнэ тогтолт харилцан адилгүй юм. Коксжсон нүүрс нь гангийн үйлдвэрт, эрчим хүчний нүүрс нь эрчим хүч, дулаан, хий үйлдвэрлэлд ашиглагддаг. Түүнчлэн, бүлэг бүрд дотоод болон гадаад зах зээлийн өнгөрсөн болон өнөөгийн мэдээллийг багтаасан бөгөөд ойрын ирээдүйд зах зээлд тохиолдож болзошгүй өөрчлөлтийг тусгалаа.

Зураг 5. Монголын нүүрсний салбар



1 2015 онд экспортын 78,8%-ийг эрдэс бүтээгдэхүүн бүрдүүлсэн бөгөөд үүний 11,9%-ийг нүүрс дангаараа эзэлж байна. Харин 2016 оны жилийн эцсийн байдлаар экспортод эзлэх нүүрсний хувь 19,8% болж 8 пунктээр өсжээ.

Судалгааны гол үр дүн:

Эрэлт:

- Монгол Улсад өнөөгийн байдлаар 17 дулааны цахилгаан станц болон дулааны станц үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дотоод эрэлтийн 85.9 хувийг бүрдүүлжээ. Сүүлийн 10-аад жилд дотоод эрэлт харьцангуй тогтвортой байсан нь томоохон бүтээн байгуулалт хийгдээгүйтэй холбоотой.
- Хэдийгээр, ойрын 2-3 жилд бүтээн байгуулалт зогсонги байдалтай байх ч, ирэх 10 жилийн хугацаанд дотоодын гол хэрэглэгч болох эрчим хүчний салбарт томоохон бүтээн байгуулалт хийгдэх төлөвтэй байна. Тодруулбал, төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар 18 дулааны цахилгаан станц баригдана. Энэ нь дотоодын нүүрсний хэрэглээг 12.6 сая тонноор буюу өнөөгийнхөөс 3 дахин өсгөнө.
- Гадаад зах зээлд эрчим хүчний нүүрсний эрэлт өнгөрсөн жилүүдтэй харьцуулбал харьцангуй сул байхаар хүлээлттэй байгаа. Энэ нь улс орнууд агаарын бохирдлыг бууруулах амлалт авч, амлалтдаа хүрэхээр ажиллаж буйтай холбоотой юм. Харин коксжих нүүрсний эрэлт бага зэрэг өсөхөөр хүлээгдэж байна. Учир нь хэд хэдэн томоохон бүтээн байгуулалтын ажил ирэх жилүүдэд хэрэгжинэ.

Нийлүүлэлт:


- 2015 онд олборлосон нүүрсний 32,6% дотоод, 67,4% гадаад зах зээлд нийлүүлэгджээ. Гадаад зах зээл дэх нийлүүлэлтийн 96,8% зөвхөн Хятад руу хийгдсэн ба үүний 90% нь коксжих нүүрс юм.
- Тус онд Монгол Улс дэлхийн тэргүүлэх нүүрс экспортлогчдын жагсаалтын 9-р байранд эрэмбэлэгдсэн. 2017 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд дурдсанаар, 23 сая тонн нүүрсийг (коксжих болон эрчим хүчний нүүрс) гадаад зах зээлд нийлүүлэх ба ингэснээр Монгол Улсын эзлэх байр урагшилна.
- Өнгөрсөн жилүүдэд БНХАУ-ын засгийн газар хэд хэдэн шийдвэр, тогтоол гаргасан нь Монголын экспортод нөлөөлнө. Тухайлбал, 2016 оны 12 сарын 1-ээс Ганц мод боомтоор гарч буй эрдэс бүтээгдэхүүнд Хятадын орон нутгийн захиргаа нэмэлт төлбөр авч эхлэх, 2017 оны өвлийн улиралд гангийн үйлдвэрүүдийн 30 хувийн үйл ажиллагааг түр зогсоох гэх мэт.

Коксжих болон эрчим хүчний нүүрсний үнэ ойрын жилүүд харьцангуй бага хэвээр байхаар байна. Хэдийгээр 2016 оны эхэнд нийлүүлэлтийн хомсдолоос үүдэн нүүрсний үнэ өссөн боловч энэ өсөлт урт хугацаанд хадгалагдах боломж хомс байна. Тодруулбал, сүүлийн жилүүдэд томоохон нүүрс ашигладаг эрчим хүчний станцууд татан буугдаж байгаа бөгөөд энэ хандлага цаашид ч хадгалагдахаар байгаа нь эрчим хүчний нүүрсний үнэд сөргөөр нөлөөлнө. Томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд ирэх жилүүдэд хэрэгжихээр хүлээгдэж байгаа боловч энэ нь коксжих нүүрсний үнийн бууралтыг сааруулах төдий бөгөөд өсгөж чадахгүй юм.

Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа

Монгол Улс төмрийн хүдрийн арвин нөөцтэй. Ашигт малтмалын газрын 2016 оны тайланд дурдсанаар нийт геологийн нөөц 1,7 тэрбум тонн байна. Нийт 63 орд бүртгэгдсэний 6 нь л 50 сая тонноос их хүдэртэй, дийлэнх ордын агуулга сайн биш (16.5% - 55.6% Fe, магнетид) тул баяжуулах шаардлага ихтэй, дэд бүтцэд холбогдоогүй. Төмрийн хүдрийн гол нөөц Дархан-Сэлэнгийн бүсэд байдаг. Төмрийн хүдрийн олборлолт 2005 оноос эхэлсэн бөгөөд 2011 оноос хойш жилд дунджаар 6 сая тонн хүдэр Хятадын зах зээлд экспортолж байна.

Зураг 6. Монголын төмрийн хүдрийн экспорт, тэрбум ам.доллар



2013 онд төмрийн хүдрийн экспорт дээд цэгтээ хүрч, Монголын нийт экспортын 15%-ийг бүрдүүлж байсан боловч түүнээс хойш дэлхийн зах зээл дээрх үнийн бууралтаас шалтгаалж төмрийн хүдрийн экспортын орлого эрс буурсан юм. 2016 онд төмрийн хүдрийн экспорт нийт экспортын 5%-ийг бүрдүүлэх болов.


Эдүгээ зөвхөн Болд Төмөр Ерөө Гол компани уурхайгаа төмөр замд холбосон давуу талаа ашиглан үйл ажиллагаа явуулж байна. Тус компани баяжуулсан хүдрээ Хятадын Бугатын гангийн үйлдвэрт нийлүүлдэг. Гэхдээ зүй ёсны монополь болох Улаанбаатар төмөр зам тус компанийн ачаа тээвэрт харьцангуй өндөр тариф тогтоож буй нь нэг гол бэрхшээл болоод байна.

Төмрийн хүдрийг дотооддоо боловсруулан ган үйлдвэрлэх санаачилга гарч байгаа боловч дотоодын гангийн хэрэглээ үр ашигтай хүчин чадалтай харьцуулахад маш бага, экспортын стандарт өндөр, өрсөлдөөн их зэрэг шалтгааны улмаас гангийн үйлдвэр барих нь үр ашиггүй гэж үздэг.

Судалгааны гол үр дүн

- Австрали төмрийн хүдрийн нөөцөөр дэлхийд тэргүүлдэг, 24 тэрбум тонн цэвэр төмөр бүхий 54 тэрбум тонн хүдрийн нөөцтэй. Түүний дараа Орос 25, Бразил 23, Хятад 23, АНУ 11,5 тэрбум тонн төмрийн хүдрийн нөөцтэй.
- 2015 онд дэлхийд нийт 2 тэрбум тонн хүдэр олборлосны 40%-ийг Австрали, 21%-ийг Бразил, 7%-ийг Энэтхэг, 6%-ийг Хятад олборложээ.
- Нийт олборлосон хүдрийн 98% нь ган үйлдвэрлэхэд ашиглагддаг тул төмрийн хүдрийн эрэлтэд гангийн зах зээл гол нөлөө үзүүлдэг. 2015 онд дэлхийд нийт 1,6 тэрбум тонн ган үйлдвэрлэжээ. Энэ нь 2005 оны үйлдвэрлэлээс 41% өссөн үзүүлэлт юм. Уг өсөлтийн 95%-ийг Хятад бүрдүүлжээ. Харин 2005-2015 онд дэлхийн ган үйлдвэрлэлийн хүчин чадал 72% өссөн бөгөөд үүний дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал 741 сая тонн илүүдэлтэй болоод байна.
- Энэ хугацаанд гангийн хэрэглээ 43% өссөн бөгөөд энэ өсөлтийг 72%-ийг Хятад, 20%-ийг Азийн бусад орон, тэр дундаа Энэтхэг бий болгожээ. Нийт үйлдвэрлэсэн гангийн 50%-ийг барилга, дэд бүтцийн салбарт ашигладаг бол 16%-ийг механик тоног төхөөрөмж, 13%-ийг автомашин, 21%-ийг бусад салбарт ашигладаг.
- Хятадын гангийн үйлдвэрлэл 2015 онд 803,8 сая тонн хүрсэн бөгөөд энэ эрэлтийг хангахын тулд Хятад 950 сая тонн гаруй төмрийн хүдрийг 55 улсаас импортолжээ. Австрали, Бразилын экспорт Хятадын нийт импортын 64% ба 20%-ийг тус тус бүрдүүлсэн бол Монголын экспорт дөнгөж 0,6%-ийг бүрдүүлжээ.
- Төмрийг дахин боловсруулах нь төмрийн хүдрийн эрэлтийг бууруулдаг нэг чухал хүчин зүйл. 2015 онд дэлхий нийтээр 650 сая тонн хаягдал төмөр хайлуулжээ. Энэ нь нийт үйлдвэрлэсэн гангийн 40% болж байгаа юм. Хаягдал төмрийн нийлүүлэлт цаашид үргэлжлэн өснө. Төмөрлөгийн үйлдвэрийн технологийн дэвшлийг бас анхаарах хэрэгтэй. 1970, 1980-аад онд орчин үеийн гангийн үйлдвэрүүд 100 кг ган үйлдвэрлэхийн тулд дунджаар 144 кг түүхий эд зарцуулдаг байсан бол өдгөө энэ тоо 115 кг болж буурчээ.
- Хятад Улс өндөр орлоготой ангилалд шилжиж, өсөлт нь удаашрах тул төмрийн хүдрийн эрэлт урт хугацаандаа төдийлөн огцом өсөхөөргүй байна. Гэхдээ Энэтхэг, АСЕАН-ы орнуудад хотжилт, аж үйлдвэржилт эрчимтэй явагдаж, гангийн хэрэглээ нэмэгдсэнээр уг түүхий эдийн эрэлт өсөх төлөвтэй байна.
- Дэлхийн төмрийн хүдрийн импорт 2015 онд 1420 сая тонн буюу 90,3 тэрбум ам.долларт хүрчээ. Үүний 80%-ийг Хятад, Япон, Өмнөд Солонгос импортолжээ. Харин дэлхийн нийт экспортын 80%-ийг Австрали, Бразил гаргажээ.
- Төмрийн хүдрийн үнийн 2000 оноос хойших өсөлтийг Хятад тэргүүтэй зарим орны хурдацтай аж үйлдвэржилт буюу төмрийн хүдрийн эрэлтийн өсөлтөөр тайлбарлаж болно.

Зураг 7. Төмрийн хүдрийн үнэ, ам.доллар/тонн



Төмрийн хүдрийн үнэд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- ◀ Нийт эдийн засгийн нөхцөл байдал: Дэд бүтцийн хөгжил, хотжилт
- ◀ Уурхайд хийгдэж буй хөрөнгө оруулалт, шинэчлэл
- ◀ Эрчим хүчний үнэ: Сүүлийн жилүүдэд тээврийн зардал буурсан
- ◀ Олигополь зах зээл: Вале, Рио Тинто, БиЭйчБи Биллитон компаниуд зах зээлийн 50%-ийг хянадаг, гэхдээ Хятадын Төмөр ба Гангийн Холбоо хүчтэй тоглогч болсон
- ◀ Зах зээл дээрх спекуляц
- ◀ Монголын төмрийн хүдрийн үнийг Өвөр Монголын гангийн үйлдвэрүүд тогтоодог

Үнийн гол таамаглал:

- ◀ Дэлхийн банк: 2017-2020 онд тонн тутам нь 55-56,2 ам.доллар байна
- ◀ Морган Стэнли: Нийлүүлэлт илүүдэлтэй байх тул 2017-2018 онд 58 ам.доллар орчим байна
- ◀ Блүүмбэрг: Богино хугацаанд хэт нийлүүлэлттэй байх тул үнэ өсөхгүй, харин 2020 оноос эхлэх жил тутам 50 сая тонн төмөр дутагдах тул үнэ өснө.

“Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт: Ерөнхий тэнцвэрийн загварчлал” судалгаа

Тус судалгааны зорилго нь Ерөнхий тэнцвэрийн (CGE) загварын тусламжтайгаар эдийн засгийн ажиглагдсан болон үл ажиглагдсан өөрчлөлтийг 200-2012 оны тоон мэдээлэлд суурилан тодорхойлоход оршино. Эдгээр өөрчлөлтийг тодорхойлсноор дараагийн удаа энэ загварын тусламжтайгаар эдийн засгийн таамаглал хийх боломж бүрдэнэ. Загварт ашиглагдах өгөгдлийн санг ҮСХ-ны салбар хоорондын тэнцэлд тулгуурлан бэлтгэж, Монголын эдийн засгийн онцлог шинжийг тусгасан “MN-CGE ерөнхий тэнцвэрийн загвар”²-ын динамик хувилбарыг ашиглалаа. Энэ загвар нь загварчлалын GEMPACK орчны програмд тохируулан бэлтгэгдсэн.

Судалгааны гол үр дүн 2005-2012:

- Энэ хугацаанд Монгол Улсын экспортын, ялангуяа эрдэс, бүтээгдэхүүний эрэлтийн огцом нэмэгджээ. Гэхдээ үүнд дотоод хүчин зүйлс гэхээсээ илүүтэйгээр Хятадын аж үйлдвэржилт болон хотжилт буюу гадаад хүчин зүйлс нөлөөлжээ.
- Эдийн засаг дахь капитал/хөдөлмөрийн харьцаа нэлээд өөрчлөгдсөн бөгөөд энэ нь уул уурхайн салбар (хөдөлмөр багтаамж багатай)-ын өсөлт өндөр байсантай холбоотой.
- Өрхүүдийн таашаалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан. Тодруулбал, 2005 онд арьс, арьсан бүтээгдэхүүний дөнгөж 0.8 хувийг өрхүүд худалдан авч байсан бол 2012 онд энэ хувь 40.4 болж 50 дахин өсжээ. Энэ хандлага бусад бүтээгдэхүүнд ч ажиглагдсан. Тиймээс өрхүүд импортын бүтээгдэхүүнээс илүү дотоодод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн худалдан авахыг илүүд үзэж байна.
- Эдийн засгийн салбарууд дахь технологийн дэвшил бусад улстай харьцуулахад нэлээд доогуур байжээ. Тухайлбал, энэ хугацаанд уул уурхайн салбарт 4.5%, үйлчилгээний салбарт 0.2%-ийн технологийн дэвшил гарчээ. Харин хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарт технологийн дэвшил гарсангүй.
- Эдийн засгийн бүтцэд гарч буй өөрчлөлтөөс Голланд өвчний шинж тод ажиглагдав. Тиймээс эдийн засагт микро түвшний шинэчлэл хийх шаардлага байна.

2 Economic Research Institute has been developing the “MN-CGE model” independently since 2014.

Жижиг, дунд үйлдвэрийн хэлцлийн зардлын судалгаа

Манай улсын хувьд ЖДҮ-ийн салбарын зардлын томоохон хувийг эзэлдэг хувийн хэвшил ба төрийн хоорондын харилцаанаас үүсэх хэлцлийн зардлыг микро судалгаанд үндэслэн тооцох нь чухал ач холбогдолтой юм. Хэлцлийн зардлыг зах зээлийн, зах зээлийн бус гэж ангилах ба төрийн байгууллагын хүнд суртлаас үүдэн хөгжиж буй орнуудад зах зээлийн бус хэлцлийн зардлын хэмжээ маш их байдаг. Зах зээлийн бус хэлцлийн зардалд бизнесийн зөвшөөрөл авах, элдэв хүнд суртлыг давахад зарцуулж буй хүн хүч, цаг хугацаа, албан тушаалтнуудад өгөх авлига зэргийг багтаана.

Монголбанкны захиалгаар хэрэгжсэн тус судалгаа нь манай улсын ЖДҮ-ийн үйл ажиллагаанд тулгардаг зах зээлийн бус хэлцлийн зардлыг түүвэр судалгаагаар нарийвчлан судалсан. Энэ хүрээнд ЖДҮ-ийн хөгжлийн талаарх өөрийн орны болон олон улсын хэмжээнд хийгдсэн онолын ба эмпирик судалгааны ажлуудын тоймыг бэлтгэж, ЖДҮ-ийн хөгжлийн асуудлаар ажилладаг төрийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын удирдлагуудтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Мөн 2015-2016 онд Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй 1541 аж ахуйн нэгжээс зах зээлийн бус хэлцлийн зардлын дэлгэрэнгүй түүвэр судалгаа авч, уг хэлцлийн зардлыг бизнесийн үйл ажиллагааны дараах үе шат бүрээр нарийвчлан үнэлсэн. Үүнд:

- ◀ Албан ёсны бүртгэлтэй холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Тусгай зөвшөөрөл ба мэргэжлийн хяналттай холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Гэрээний хэрэгжилттэй холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Төрийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Татвартай холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Гааль, гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Дэд бүтэцтэй холбоотой хэлцлийн зардал,
- ◀ Санхүүгийн байгууллагатай харилцахтай холбоотой хэлцлийн зардал эдгээр болно.

Судалгааны гол үр дүн

- Судалгаанд хамрагдсан 1541 аж ахуйн нэгж сүүлийн нэг жилийн хугацаанд дунджаар 9 сая төгрөгийн зах зээлийн бус хэлцлийн зардлыг дээрх үйл ажиллагаануудад зарцуулжээ. Төрийн хүнд суртлыг давах энэхүү зардал дунджаар аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын 4,4 хувьтай тэнцэж байгаа юм. Тухайлбал, борлуулалтын орлогынхоо 20%-иас дээш хэмжээний хэлцлийн зардалтай тулгарсан аж ахуйн нэгж 4%-ийг эзэлж байгаа бол уг дарамт борлуулалтын орлогын 2%-иас доош байх аж ахуйн нэгж 58%-ийг эзэлж байна.

Зураг 8. Нийт хэлцлийн зардлын ачааллын харьцуулалт (%)



- ◀ Зураг 8-д үзүүлснээр, уг хэлцлийн зардал бичил бизнес эрхлэгчид болон аж үйлдвэр, үйлчилгээний салбарт илүү их дарамт учруулж байна.
- ◀ Татвар ба гаалийн байгууллагатай харилцахад гарах хэлцлийн зардал нийт хэлцлийн зардлын 73%-ийг эзэлж байна.
- ◀ Зардлын төрлөөр ангилж харвал шууд бус зардал буюу төрийн хүнд суртлыг давахад зарцуулсан цаг хугацааны алдагдсан боломжийн өртөг нь нийт хэлцлийн зардлын 51%-ийг бүрдүүлж байна.
- ◀ Судалгаанд хамрагдсан бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн 12% нь бизнесээ явуулахын тулд төрийн албан хаагчдад ямар нэг бэлэг, албан бус төлбөр төлсөн бөгөөд энэ нь тэдний тулгарсан нийт хэлцлийн зардлын 3 хувьтай тэнцүү байжээ.

Монголын өрхийн секторын стресс тестийн загвар

Энэхүү судалгааны ажлаар Монголын өрхийн секторын стресс тестийн симуляцийн загварыг боловсрууллаа. Уг загвар нь 2012, 2014 оны өрхийн Нийгэм Эдийн Засгийн түүвэр судалгааны тоон өгөгдөл ашиглан макро эдийн засгийн шокын үе дэх өрхүүдийн санхүүгийн дархлааг судлахад зориулагдсан.

Загварт Монголын өрхүүд болон банкны салбарын онцлог шинж чанаруудыг тусгасан ба энэ нь Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны гол үзүүлэлтүүдтэй нийцэж байсан. Уг загвараар өрхүүдийн санхүүгийн дархлааг судлахаас гадна эрсдэлтэй өрхүүдийн банкны салбарт үзүүлэх нөлөөг тооцох боломжтой юм.

- ◀ Стресс тестийн өмнөх тооцооллын үр дүн сөрөг санхүүгийн баланстай өрхүүдийн эзлэх хувь дунджаар 14.4% байгааг харуулж байна. Орлогын тархалтаар ажиглахад бага орлоготой өрхүүдийн хувьд энэ нь хамгийн өндөр 38.1% байна.
- ◀ Стресс тестийн өмнөх эрсдэлтэй өрийн харьцаа 2014 оны байдлаар 7.2% байгаа нь Монгол улсад зээлдэгчдийн сөрөг санхүүгийн баланстай өрхүүдээс хамаарах хамаарал өндөр байдгийг харуулж байна.
- ◀ Стресс тестийн үр дүнгээс харахад өрхүүд зээлийн хүү, хэрэглээний барааны үнэ, хөрөнгийн үнэ болон ажилгүйдлийн түвшний шоконд өртөх эмзэг байдал өндөр байна.
- ◀ Эдгээрээс зээлийн хүү болон хэрэглээний үнийн шокоос үүдэлтэй өрхийн зээлийн алдагдал нь анхаарал татахуйц өндөр байна. Тухайлбал үндсэн хэрэглээний барааны үнэ 5% өсөх нь эрсдэлтэй өрийн харьцааг 0.7 пунктээр нэмэгдүүлж байгаа бол зээлийн хүү 5% өсөхөд энэхүү харьцаа 1.22 пунктээр нэмэгдэж байна. Стресс тестийн өмнөх эрсдэлтэй өрийн харьцаа 7.2% байгаагаас энэхүү өсөлтүүдийн санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө их байх нь тодорхой.
- ◀ Судалгаагаар малчин өрхүүд болон тэтгэврийн насны бүлэг санхүүгийн эрсдэлд өртөх магадлал өндөртэй байна. Бүхэлдээ эдгээр үр дүнгүүд өрхүүдийн өрийн дарамт нэмэгдвэл өрхийн салбарын санхүүгийн хэврэг байдал өсөхийг харуулж байна.

Энэ судалгааны ажил нь Монголын банкны системийн микро суурьтай стресс тестийн цогц тогтолцоог хөгжүүлэх эхлэлийн суурь юм. Эцэст нь өрхүүдийн санхүүгийн тэнцлийн тоон үзүүлэлтүүдийн боломжоос шалтгаалан загварыг илүү сайжруулах боломжтой.

Дундаж давхаргын судалгаа

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах бодлогыг 1990-ээд оноос хойш Монголын Засгийн газрууд баримталж ирсэн боловч эдгээр бодлого иргэдийн амьжиргаанд төдийлөн үр нөлөө үзүүлэхгүй байна гэсэн шүүмжлэл байнга гарч байв. Гэхдээ сүүлийн арваад жилд эдийн засаг хурдтай өсөж, ядуурлын түвшин эрс буурсан билээ. Тухайлбал, 2010-2015 онд эдийн засаг жилд дунджаар 10% өсжээ. Ингэснээр, ядуурлын түвшин 2010 онд 38.7% байсан бол 2014 онд 21.6% болж буурчээ (ҮСХ, 2015).

Энэхүү судалгаанд 2002-2014 онд Монголын дундаж давхарга хэрхэн өөрчлөгдсөнийг олон янзын тодорхойлолт ашиглан хэмжсэн. Улмаар сонгосон нэг тодорхойлолтоо ашиглан бага, дунд, өндөр орлоготой бүлгийн нийгэм-эдийн засгийн шинжүүдийг харьцуулсан юм. Энэ судалгаанд Үндэсний статистикийн хорооны жил бүр гүйцэтгэдэг Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны 2002-2003, 2007-2008, 2014 онуудын тоон мэдээллийг ашиглав.

Судлаачид дундаж давхаргыг тогтоохдоо судалгааныхаа зорилгоос хамааран өөр өөр тодорхойлолт ашигладаг. Зөвхөн нэг үзүүлэлтээр дундаж давхаргыг тодорхойлох хэцүү. Эдийн засагчдын голчлон хэрэглэдэг тодорхойлолтууд өрхийн нэг хүнд ногдох орлого, эсвэл зарлагын үнэмлэхүй болон харьцангуй хэмжигдэхүүнд тулгуурладаг.

Үнэмлэхүй аргууд өрхийн орлого, зарлагын янз бүрийн босго утгыг ашигладаг. Жишээлбэл, Азийн хөгжлийн банк 2010 онд хийсэн судалгаандаа нэг хүнд ногдох өдрийн хэрэглээ нь 2-20 ам.доллар (худалдан авах чадвар тооцсон) байх өрхийг дундаж давхарга гэж тодорхойлсон. Уг судалгаагаар Монголын дундаж давхаргын эзлэх жин 70% байв. Дэлхийн банкны 2010 оны судалгаанд өдрийн нэг хүнд ногдох хэрэглээ 2-26,5 ам.доллар (худалдан авах чадвар тооцсон) байх өрхийг дундаж давхарга гэж тодорхойлсон. Тэгвэл дэлхийн дундаж давхаргыг тодорхойлох судалгаанд босгыг өрхийн нэг хүнд ногдох орлого, хэрэглээ 10-100 ам доллар гэж тодорхойлсон байдаг.

Харьцангуй аргууд нь тухайн өрхийг бусад өрхтэй харьцуулдаг. Тухайлбал, нийт өрхийн орлогын тархалтад үндэслэн өрхүүдийг таван тэнцүү бүлэгт (квантил) хувааж, II-IV, эсвэл III-IV бүлгийг дундаж давхарга гэж тодорхойлох арга байдаг. Гэхдээ ингэж тодорхойлсон дундаж давхаргын эзлэх жин тогтмол 60% эсвэл 40% байдаг. Бусад харьцангуй аргууд нь медиан өрхийн орлогын 67-200% (эсвэл 75%-125%) завсарт орлого нь байх өрхийг дундаж давхарга гэж тодорхойлдог.

Бидний судалгаагаар, 2002-2014 онд Монголын дундаж давхаргын эзлэх хувь орлогод үндэслэсэн бараг бүх тодорхойлолтын хувьд нэмэгджээ (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Дундаж орлоготой бүлгийн эзлэх хувь,
2002-2014 он, сонгосон тодорхойлолтоор

| Дундаж давхаргын тодорхойлолт | 2002 | 2008 | 2014 |
|---|-------|-------|-------|
| Өрхийн нэг хүнд ногдох орлого 2-26.5 ам.доллар (худалдан авах чадвар тооцсон) | 88.7% | 85.5% | 84.8% |
| Өрхийн нэг хүнд ногдох орлого 10-100 ам.доллар (худалдан авах чадвар тооцсон) | 27.3% | 26.6% | 68.6% |
| Медиан өрхийн орлогын 67%-200% | 50.9% | 49.5% | 61.0% |
| Медиан өрхийн орлогын 75%-125% | 26.3% | 24.9% | 32.8% |

Монголын дундаж давхарга тэлсний гол шалтгаан нь бага орлоготой өрхүүдийн орлого хурдтай өсөж, дундаж орлоготой бүлэг рүү олноороо шилжсэнтэй холбоотой.

2002 оноос хойш өрхийн бодит орлого эрс өсөж, орлогын тархалтын муруй баруун тийш шилжжээ (Зураг 9). Тухайлбал, 2002-2008 онд өрхийн нэг хүнд ногдох бодит орлого 10% орчим нэмэгдсэн бол 2008-2014 онд өрхийн нэг хүнд ногдох бодит орлого хоёр дахин нэмэгджээ.

Зураг 9. Өрхийн орлогын тархалт, 2002 оны үнээр



Гэхдээ сүүлийн жилүүдэд хот, хөдөөгийн өрхүүдийн орлогын ялгаа ихээхэн нэмэгдсэн. 2002 онд хот, хөдөөгийн өрхүүдийн дундаж орлого ойролцоо, 1,8 сая төгрөг байсан бол 2014 онд хотын өрхийн орлого хөдөөгийн өрхийн орлогоос 28% илүү болжээ. Энэ шалтгааны улмаас хөдөөгийн дундаж давхаргын эзлэх хувь хотынхоос 3 нэгж хувиар бага болжээ.

Хот хөдөөгийн өрхийн орлогын ялгааны нэг гол шалтгаан нь хотын өрхүүдийн орлогод цалин, тэтгэврийн эзлэх хувь нэмэгдэж, гол эх үүсвэрүүд болсонтой холбоотой. 2002 онд хотод өрхийн бизнесийн орлого, хөдөөд өөрийн үйлдвэрлэлийн хэрэглээ нь өрхийн орлогын 27% ба 38%-ийг тус тус бүрдүүлдэг байв. Гэвч 2014 гэхэд эдгээр орлогын эзлэх хувь эрс буурч, тус бүр 13% ба 18% хувь болжээ.

Богино болон дунд хугацааны эдийн засгийн төсөөлөл

2015-2016 онд “Голомт” банкны захиалгаар Монгол Улсын макро эдийн засгийн богино болон дунд хугацааны төсөөлөл боловсруулах судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Богино болон дунд хугацааны эдийн засгийн төсөөллийг хийхдээ олон улсын байгууллагууд, Монголбанкны ашигладаг аргачлалыг ашигласан бөгөөд ДНБ-ий эрэлтийн талын таамаглал болох хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, засгийн газрын зардал, импорт, экспортын төсөөллүүд, ДНБ-ий нийлүүлэлтийн тал болох хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ, цахилгаан, хий, уур, бүтээгдэхүүний цэвэр татварын төсөөллүүдийг тус тус хийлээ. Тухайн үзүүлэлтийн онцлогоос нь хамааруулж сонгох замаар шууд төлөвлөгөөнд үндэслэн зарим үзүүлэлтийг таамаглах, улирлын нөлөөг засварласан авторегрессив хөдөлгөөнт дундаж (SARIMA)-ийн загвар, бейсийн вектор авторегрессив загварыг ашиглан эдийн засгийн өсөлтийн төсөөллийг хэт богино хугацаанд таамаглалаа. Тодруулбал, бейсийн вектор авторегрессив загвараар дараах салбар болон ДНБ-ий зардлын талын хувьсагчдын таамаглалыг хийв. Үүнд:

- ◀ Барилгын салбар
- ◀ Үйлчилгээний салбар
- ◀ Худалдааны салбар
- ◀ Боловсруулах салбар
- ◀ Уул уурхайн салбар
- ◀ Хувийн хэрэглээ
- ◀ Хөрөнгө оруулалт.

Урсгал данс талаас экспорт (нүүрс, зэс, төмрийн хүдэр, газрын тос, бусад), импорт (аж үйлдвэрийн орц, барилгын материал, машин тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт), шилжүүлэг, үйлчилгээ (тээврийн үйлчилгээ, аялал жуулчлал), орлогын (тухайлбал, Оюу толгойн үйлдвэрлэлийн төлөвлөгөө) таамаглалыг авч үзсэн бол хөрөнгийн данс талаас хөрөнгийн данс, гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалтын таамаглалыг авч үзэх замаар төлбөрийн тэнцлийн төсөөллийг хийв.

Төлбөрийн тэнцэл, улсын төсөв, дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллүүд, мөнгөний бодлогын төлөв, гадаад секторын нөхцөл байдалд үндэслэн эндоген хувьсагчдыг сонгох замаар бейсийн вектор авторегрессив загварыг үнэлж, макро эдийн засгийн гол хувьсагчид болох эдийн засгийн өсөлт, инфляц, валютын ханш зэргийн таамаглалыг богино болон дунд хугацаанд хийлээ.

Дунд хугацааны таамаглалыг (2017-2019) санхүүгийн програмчлал ашиглан хийсэн бөгөөд санхүүгийн програмчлалыг ДНБ-ий эрэлт болон нийлүүлэлт талын таамаглалын нийцлийг харьцуулахад мөн ашиглалаа.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ

Тус хүрээлэн “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 2016 оны 9-10-р сард гүйцэтгэсэн. Энэ үнэлгээнд Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дундговь, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий зэрэг 9 аймгийн 113 сумыг хамруулсан.

Сайн засаглалын үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Монгол Улсын бүх сумын засаглалын түвшнийг жилийн гүйцэтгэлээр үнэлэх бөгөөд энэ үнэлгээнд үндэслэн болзол хангасан сумд тодорхой хэмжээний урамшуулал авах юм. Сумдын засаглалын түвшнийг үнэлэхдээ тусгайлан боловсруулсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх аргачлалд тулгуурласан. Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм журмын хүрээнд сумдын засаглалыг дараах 6 түвшинд тодорхойлохоор авч үзсэн. Үүнд:

1. 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэхэд иргэдийн оролцоог хангаж буй байдал
2. 2016 оны төсвийн төлөвлөлт, бэлтгэлийг хангасан байдал
3. 2015, 2016 оны төсвийн талаар олон нийтэд ил тод мэдээлж буй байдал
4. 2015 оны төсвийн гүйцэтгэл
5. 2015 оны төсвийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, хяналт шалгалт хийсэн байдал
6. 2015 оны төсвийн гүйцэтгэлээр бий болсон сумын хөрөнгийн өмчлөл, ашиглалтын байдал.

Энэхүү үнэлгээнд 2014-2016 онд ОНХС-д улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хууль журмын дагуу хэрхэн зарцуулсан талаар сумдын гүйцэтгэсэн ажлын тайлан, төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой баримт бичгийг үндэслэн тусгай аргачлалаар үнэлгээг гүйцэтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн ажилд дараах хууль эрхийн актыг үнэлгээний шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан. Үүнд:

- ◀ Төсвийн тухай хууль
- ◀ Нэгдсэн төсвийн тухай хууль,
- ◀ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- ◀ Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль
- ◀ Сангийн сайдын 2012 оны 244, 290, 264 дүгээр тушаал
- ◀ Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал
- ◀ Бусад холбогдох эрх зүйн актууд